

ОРЧИН ЦАГИЙН ТҮРЭГ, МОНГОЛ ХЭЛНИЙ
БОДИТ ӨНГӨРСӨН ЦАГИЙН ТУХАЙ

М.Ууганбаяр

Орчин цагийн түрэг, монгол хэлнээ бодит өнгөрсөн цагийн болц цагийн тусгай утга ерөнхий болцын бодит баримтын утга, өнгөрсөн цагийн энгийн одоо цагийн утгын нэгдлээр үүснэ. Энэ утга үйл явдлыг өнгөрсөн цагийн бодит бие даасан баримт гэж үйлийн өнгөрсөн цагт яригчийн нүдний өмнө хэрэгжсэнийг заах (Эргин, 1997:298) ба дараагийн цаг хугацааны үндэс суурийн хувьд чухал үр дүнг илтгэнэ. Энэхүү утга хамгийн бага хэмжээгээр хам эхээс хамаарах бөгөөд эл утга тодроход хамгийн доод түвшний хам эх буюу ерөнхий өнгөрсөн цагийн хэлбэрээс өөр ямар нэг махбодыг агуулаагүй үгэлбэр хангалттай байна. Энэхүү утга бидний дээр өгүүлсэн шиг ерөнхий өнгөрсөн болц цагийн утгууд дундаа хамгийн бие даасан шинжтэй бөгөөд үйл үгийн хэлбэрүүдийг хамгийн өргөнөөр хамарч ихэд түгээмэл хэрэглэгддэг. Бодит өнгөрсөн цагийн утга үйл явдлын бүхэл шинж цагт байрших утгын нэгдлээр хэрэгжинэ. Энэ утгын хэрэглэгдэж болох хэд хэдэн хам эхийн төрөл байж болно. Бодит өнгөрсөн цагийн утга үгийн нарийвчлал үйл явдал хэрэгжихтэй холбогдох хам эх цагийн нарийвчлалгүйгээр өнгөрсөн үйл явдлыг нотолж чадна.

Бодит өнгөрсөн цаг орчин цагийн түрэг хэлнээ -di хэлбэрээр илэрнэ. Энэ нөхцөл хамгийн өргөн хэрэглэгддэг утгаасаа болж түрэг хэл зүйд өнгөрсөн төлөв, мэдүүлэх хэв маягийн энгийн төлөв, турших өнгөрсөн (Бангуоглу, 1995:458), үзэгдэх өнгөрсөн (Эргин, 1997:298) үзэгдэх өнгөрсөн (Аксан, 1997:185) хэмээн нэрлэгддэг. Бодит өнгөрсөн цаг орчин цагийн монгол хэлнээ -лаа, -в, -сан хэлбэрээр илэрнэ. Монгол хэл зүйд энгийн өнгөрсөн, /үнэмлэхүй/ өнгөрсөн (Гисонг, 1998:27, 42-43) магад өнгөрсөн (Бадан, 1989:25, 26) гэж нэрлэдэг. Т.Бангуоглу (1995:458) орчин цагийн түрэг хэлнээ өнгөрсөн төлөвийн (ерөнхий өнгөрсний) хэлбэр мэдүүлэх хэв маягтай энгийн төлөв болохын хувьд өнгөрсөн цагийг өргөнөөр хамаарах утгатай байж, үйлдэгчийн туршлага заримдаа гарцаагүй шийдвэрт тулгуурласан хэллэгийг үүсгэдэг. Мөн энэхүү шалтгаанаар турших өнгөрсөн гэх нэрийг авсан ба энд болох үйлдэх нь эхлээд төгссөн, эсвэл төгсөөгүй байж болох тухай бичээд доорх жишээг үзүүлж байна.

Avcı tavşanı vurdu

Анчин туулайг буудав.

Samsun`dan ne zaman döndünüz?

Самсунаас хэзээ буцсан бэ?

Yağmur dindi

Бороо намжив

Paraya kıydim

(Би) мөнгийг үрж цацсан.

Atlılar uzaktan göründüler

Морьтой хүмүүс холоос үзэгдэв.

Д.Аксан (1997:185) орчин цагийн түрэг хэлнээ үзэгдэх өнгөрсөн цагийн (ерөнхий өнгөрсөн хэлбэрийн) үндсэн үүрэг бол хэрэгжихэд нь ихэнхдээ гэрч болсон үйлдлийг тухайн цагаас өмнө болсныг гарцаагүй утгыг заахад оршдогийг бичжээ.

Dün işe gitmedim gezip durdum.

(Би) өчигдөр ажилдаа яваагүй хэсүүчилсээр байв.

Liseyi gezen yıl bitirdi.

(Тэр) лицейг өнгөрсөн жил дүүргэсэн.

İki ay Kuşadasında kaldılar.

(Тэд) хоёр сар Кушадад байсан.

К.Гисонгийн үзэхээр орчин цагийн монгол хэлэнд өнгөрсөн цагаар төгсгөх -лаа хэлбэр (ерөнхий өнгөрсөн -лаа хэлбэр) өгүүлэхүүнээр илэрсэн үйл явдал хэлэх үеэс өмнө болсныг зааж ерөнхийдөө энгийн /үнэмлэхүй/ өнгөрсөн цагийн утга илэрдэг ажээ.

Тэр өчигдөр Улаанбаатарт ирлээ.

Би өчигдөр “Мандухай цэцэн хатан” гэдэг кино үзлээ.

К.Гисонг орчин цагийн монгол хэлэнд өнгөрсөн цагийн -в нөхцөл (ерөнхий өнгөрсөн -в хэлбэр) өгүүлэхүүнээр илэрсэн үйл явдал хэлэх үед болсныг заах өнгөрсөн цагийг голчлон заахаас гадна тухайн үйл явдлын яригчид шууд мэдэгдсэн өөрөө нүдээр үзэж биеэр оролцон тохиолдлыг илтгэнэ хэмээн тэмдэглэжээ.

Нар мандав.

Хувьсгал ялав.

К.Гисонг орчин цагийн монгол хэлэнд тодотгон холбох -сан нөхцөл (ерөнхий өнгөрсөн -сан хэлбэр) бүрэн өгүүлэхүүний хэлбэрээр үйл явдлын энгийн үнэмлэхүй өнгөрсөн цагийг илэрхийлнэ гэв. Энэ номыг аав надад өгсөн (1994:14, 27, 42-43).

Г.Бадан (1989:25-26) орчин цагийн монгол хэлнээ магад өнгөрсөн цагийн хэлбэр (форма достоверно прошедшего времени) -лаа, -в нь хэлэх үе хүртэл хэрэгжсэн үйл явдлыг заах ба энэхүү хэлбэр яригчийн үйл явдал хэрэгжсэний ойрын гэрч болсон эсвэл үйл явдлын гэрч оролцогч мэт итгэлтэйгээр ярих нөхцөлд хэрэглэгддэгийг бичжээ.

Хоньчин Гээпэл амлалтаа биелүүлээ.

Харин ч аятайхан шалтаг оллоо.

Бумаа тэр заавраар оролдоод үзэхийг зөвшөөрөв.

Удсан ч үгүй ноос ачсан машин ирэв.

П.Бямбасан (1987:98) орчин цагийн монгол хэлнээ үйлийн цагаар тодотгон холбох нөхцөл -сан, -сэн, -сон, -сөн нөхцөл (ерөнхий өнгөрсөн -сан хэлбэр) тодорхой өнгөрсөн цагийн утгатайг заав. Жишээ нь:

Багш аль эрт ирсэн.

Энэхүү утга монгол, түрэг төрлийн хэл аялгуус болоод өөр хэлнээ ч тохиолдоно.

Д.Г.Тумашева (1986:34) татар хэлнээ гарцаагүй өнгөрсөн цагийг /катгорическое прошедшее время/ өнгөрсөн тодорхой бүрэн нэг удаагийн үйл явдлыг заадаг гэжээ.

Баладан күзен алып Каримэгэ борылды.

Тэр хүүхдээс нүдээ холдуулж Карим руу чиглэв.

Н.А.Козинцева (1984:114) армян хэлнээ төгс буюу өргөжих (аорист) хэлбэр хязгаартаа хүрсэн дангаар үйл явдлыг заадгийг бичжээ.

Karon I verdžo mi bazak džardec.

Tikin Varduhu barkuthjune hasav gagathnaketin na dngsec Karojin .

Tgan ayektur lac jejav

Хамгийн эцэст Каро шилэн аягыг хагалав.

Тикин Вардуигийн уур дээд цэгт хүрэв.

Тэр карог цохив. Хүү уйлав

А.П.Сытов (1984:193) албани хэлнээ өргөжих (аорист) хэлбэр дангаар үйл явдлыг бүхлээрээ хэрэгжсэн баримт гэж заах бодит баримтын утга заадгийг бичжээ.

Dikush më thirri me emër. Veshtrova me kujdes rreth e rrotull po nuk pashë asgjë.

Нэг хүн намайг нэрээр минь дуудав. Би анхааралтайгаар ажиглалаа. Гэвч юу ч хараагүй.

Доорх жишээнд бодит өнгөрсөн болц цагийн тусгай утга дангаараа хам эхээс ойлгогдоно.

ОТү.

Önce Demirci Efenin bir baskınla ele geçirildiğini adamlarının da yaka paза götürüldüğünü haber aldı (TB, Küçük Ağa, 419).

Эхлээд Демиржи Эфегийн нэг дайралтаар олзлогдож, хамтрагчдыг нь ч хүч хэрэглэн авч явсан тухай мэдээг авлаа.

Sabri bey hakkındaki tahkikatın olduğu gibi mahkemedeki duruşmalarında belli başlı kahramanı oldu (АНТ, Saatleri Araştırma, 96).

Сабри гуай мөрдөн байцаалтад ч, мөн шүүх хуралд ч голлох баатар нь болов.

Gecenin sesleri büyülmüş durgunluğu içinde pencerenin yavaşsacık indiği duyuldu (RHK, Yalık Emine, Memleket, 24).

Шөнийн дууг ихэсгэсэн аниргүйн дунд цох зөөлхнөөр буух нь сонсогдов.

Fasta alıp zantama aldığım polis romanlarından birini okumağa başladım bıraktım (RHK, Nilgün, 254).

ОМо.

Мароккод авч цүнхэндээ хийсэн адал явдлын романаас нэгийг нь уншиж эхлэв, орхив.

Амьдралынхаа хуудсыг анх удаа өвөртөө хийлээ. (П.Х, Уран үгийн, 252).

Би түүний хамтаар гэрт нь очлоо. Шөнө боллоо (Ц.Д, Өлзийтийн, Гологдсон, 185).

Түшмэл На яамандаа орж хүн олон байсан учир өнөө мөнгөө үзсэн ч үгүй бичгийн хайрцагт хийж цоожиллоо (Ц.Д, Гологдсон, 286).

Иймд өвгөн хулгана өөрийн ганцхүүгээ дагуулж өөр газарт Ояроод нэгэн үүр засаж нутаглан суув. (Ц.Д, Өчүүхэн дөрвөн, Гологдсон, 112).

Нацаг хавхаа зүүсэн газартаа бүр ойртон ирж байгааг багцаагаар мэдэн, Бадамд болгоомжтой байх дохио өгөн тохионоос нь татаад өөрөө бөхийн бараа харж чимээ чагнав. (С.Д, Уртын Оосор бүчгүй, 18).

Феодализмын ялзармал шатанд шилжиж хэсэг бусад болон хуваагдаж, харилцаа холбоогүй төвлөрсөн захиргаагүй ийм түүхийн балчигт шигдсэн орнуудын хаад ноёдыг Чингис хаан бут ниргэж, хил хягаарын түгжээг хамх цохиод нэгэн их гүрэн болгож нийлүүлсэн (Ц.Д, Дөрвөн оюутны, Сувдан, 29).

ОТү. aldı “авлаа”, oldu “болов”, duyuldu “сонсогдов”, başladım “эхлэв”, bıraktım “орхив”. ОМо өвөртөө хийлээ, очлоо, боллоо, цоожиллоо, суув, чагнав, нийлүүлсэн тэргүүтэн ерөнхий өнгөрсөн цагаар илрэх бодит өнгөрсөн болц цагийн тусгай утга өгүүлбэрийн аялгаар тодорч байна. Орчин цагийн түрэг монгол хэлний дээрх жишээнд өнгөрсөн цагийн бодит үйл явдал

хам эхийн тусламжгүйгээр илэрч байна. Хамгийн бие даасан тусгаар тусгай утга болохын хувьд бодит өнгөрсөн цагт үйл явдал болж өнгөрсөн нь шууд тодордог. Бодит өнгөрсөн цагийг заах байдлын утгын хувьд үйл үг голдуу хязгааргүй төгсгөлийн цэг тодорхойгүй явц байдал хийгээд тухайн үйл нь явц үе шатаас бүрдэх гүйцэтгэл байдлыг заадаг нь харагдана. Доорх жишээнд бодит өнгөрсөн болц цагийн тусгай утга өнгөрсөн үйл явдал нэмэлт заагчидтай хамт илэрнэ.

ОТү.

Bu 1911 yılı şubatında oldu ve onun cıymıyle imbike altın yapma işi sona erdi (АНТ, Saatleri Ayarlama, 53).

Энэ 1911 оны хоёрдугаар сард болсон ба түүний үхлээр цэвэршүүлж алт гаргах ажил дууссан.

Hayatta olduğunu zğrendikten sonra gznlnь refaha rahata kavuştu (RHK, Nilgьn, 54).

Түүний амьд байгааг мэдсэний дараа чиний сэтгэл тайвширч тэнийсэн.

Peri sьgьlen ve ruslar tarafından kesin olarak istendiđi kolayca kestirilebilen şartı hize saymış bir arkadaşları daha gezen hafta odasında beynine bir kurşun sıkılmış olarak bulundu (TB, Firavun Imamı, 177).

Зарлагдсан хийгээд оросуудын зайлшгүйгээр хүссэн нь амархан ойлгогдох нөхцөлийг огт үл тоосон найз нь дөнгөж өнгөрсөн долоо хоногт өрөөндөө тархидаа сум зоолгоотой олдсон.

ОМо.

Хэдэн жилийн өмнө Уламбаяр гуай бид хоёр Их Тамирын голыг уруудан явж байгаад уран Авирмэд гуайнд буусан (СЭ, Гурван өгүүллэгийнхээ, 317).

Туулын усанд сэрүүцсэний дараа Тоогийн гэрт ирж оройн хоол идэв. (СЭ, Тоогийнд, Зүүдний цагаан, 204).

Хөдөө сар шахам болоод буцаж хотод ирж хэд хоног таньдаг айлуудаар зочлон явж байгаад ажилдаа орлоо (ЧЛ, Хугараагүй, Сувдан, 148).

ОТү. oldu “болсон”, sona erdi “дууссан”, rahata kavuştu “тэнийсэн”, bulundu “олдсон”, ОМо. буусан, идэв, орлоо гэх ерөнхий өнгөрсөн цагийн хэлбэрүүдээр илрэх бодит болц цагийн тусгай утга орчин цагийн түрэг хэлнээ 1911 yılı Şubatında “1911 оны хоёрдугаар сард”, hayatta olduğunu cğrendikten sonra “амьд байгааг мэдсэний дараа”, gezen hafta “өнгөрсөн долоо хоногт” тэргүүтэн, цагийн дайврын бүлгээр, орчин цагийн монгол хэлнээ хэдэн жилийн өмнө, дараа, хэд хоног гэх зэрэг цагийн дайврын бүлэг цагийн дайвар үгээр хязгаарлагдаж ярих үе үйл явдлын үеийн хоорондох зай тодорчээ.

About Concrete Past Tense in Modern Turkish and Mongolian

In modern Turkish and Mongolian concrete past aspectual temporal special meaning derives from the union of concrete factual aspectual meaning and simple past tense meaning. This meaning points out one event as a objective concrete independent past fact and as a realization of event in front of our eyes Concrete past meaning of verb can be expressed in modern Turkish by the indicative form of -di and in modern Mongolian by the indicative forms such as -laa, -v, -san.

Номзүй

- Бадан Г.** 1989. *Категория времени в современном монгольском литературном языке*. Варшава.
- Бямбасан П.** 1987. *Үйлийн холбох нөхцөл*. Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулалт монгол хэлний үйл үгийн тогтолцоо.
- Гисонг К.** 1998. *Орчин цагийн монгол хэлний үйлийн цаг, түүний тогтолцоо*. Хэл бичгийн ухааны докторын зэрэг горилсон ганц сэдэвт бүтээл. Улаанбаатар
- Козинцева Н.А.** 1984. *Видо-временные формы предельных и неопредельных глаголов в современном армянском языке*. Теория грамматического значения и аспектологические исследования. Ленинград.
- Сытов А.П.** 1984. *Видовые оппозиций в албанском языке*. Теория грамматического значения и аспектологические исследования. Ленинград.
- Тумашева Д.Г.** 1986. *Татарский глагол Опыт функционально-семантического исследования грамматических категорий*. Казань.
- Aksan D.** 1997. *Anlambilim*. Ankara.
- Banguoğlu T.** 1995. *Türkzenin Grameri*. TDK Yay., Ankara
- Ergin M.** 1997. *Türl Dil bilgisi*. İstanbul.